



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Багануур дүүргийн 3 дугаар хорооны
“Биваангирд” ӨЭМТ-ийн данс бүртгэлээс
тээврийн хэрэгсэл хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/61 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ашиглалтын шаардлага хангахгүй болж, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 10,000,000 (арван сая) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Багануур дүүргийн 3 дугаар хорооны “Биваангирд” ӨЭМТ (О.Амаржаргал)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч, авто тээврийн улсын бүртгэл болон татварын бүртгэлээс хасуулахыг Багануур дүүргийн 3 дугаар хорооны “Биваангирд” ӨЭМТ (О.Амаржаргал)-д үүрэг болгосугай.


3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА



М. БАЯРАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2022 оны 2 сарын 17-ны өдрийн
4/58 тушаалын хавсралт



СЭЛБЭГИЙН БУЮУ ХОЁРДОГЧ ТҮҮХИЙ ЭДИЙН ЗОРИУЛАЛТААР ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЖ
ХУДАЛДАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Автомашины марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн/ Монголд ашиглаж эхэлсэн он	Зориулалт, аль улсад үйлдвэрлэсэн, өнгө	Арлын дугаар	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Эвдрэл гэмтэл
1	Багануур дүүргийн 1-р хорооны Энэрэлт өлзий ӨЭМТ	Хьюндай соната-6 53-50 БРА	2007/2014	Суудал БНСУ Цагаан	ВМНЕН41MP 7A368489	-	10,000,000	Техникийн комиссын дүгнэлтээр тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн шаардлага хангахгүй, үйлдвэрлэгдсэнээс хойш 10-аас дээш жил ашиглагдсан тул акталж данснаас хасах.
Нийт							10,000,000	